

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2018 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн
аудитын тайлан

2018 оны Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц

Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан зайлшгүй нөхцөл, шаардлага үүсээгүй байхад аймаг, сумдын төсөвт тус бүр 1-2 удаа тодотгол хийж, төсвийн орлого, зарлагыг 714.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Сүхбаатар сум
2018 он

<p>Тайланг бэлтгэсэн: Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар</p> <p>Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа</p> <p>Аудитын менежер Б.Батмөнх</p> <p>Аудитор: А.Дашбат Ц.Уртнасан, С.Баасансүрэн, Ж.Цогт, Ц.Отгонбаяр</p> <p>2018 оны 09-11 сар</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70362442, 70363036 дугаарын утас, selenge@audit.gov.mn хаягаар харилцана уу.</p> <p>ХАЯГ:Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум, аймгийн ЗДТГ-ын байрны өргөтгөлд</p>	<p style="text-align: center;">ТАЙЛАНГИЙН АГУУЛГА</p> <p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй Үндсэн мэдээлэл БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫГ БОДИТОЙ ТӨЛӨВЛӨСӨН ҮҮ?</p> <p>1.1 Орон нутгийн төсвийн орлогыг холбогдох хууль эрхийн актуудад нийцүүлэн үндэслэлтэй төлөвлөсөн эсэх?</p> <p>1.2 Орон нутгийн төсвийн зарлагыг холбогдох хууль эрхийн актуудад нийцүүлэн үндэслэлтэй төлөвлөсөн эсэх?</p> <p>1.3 Төсвийн жилийн дундуур орон нутгийн төсөвт тодотгол хийгдсэн эсэх?</p> <p>БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫГ БҮРЭН ТӨВЛӨРҮҮЛСЭН ҮҮ?</p> <p>2.1 Татварын ба татварын бус орлогыг нэмэгдүүлэх нөөц боломжийг бүрэн ашигласан эсэх?</p> <p>2.2 Төсөвт байгууллагуудын өөрийн орлогыг нэмэгдүүлэх нөөц боломж байсан эсэх?</p> <p>БҮЛЭГ 3. БАТЛАГДСАН ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ, ҮР ДҮНТЭЙ ЗАРЦУУЛСАН УУ?</p> <p>3.1 Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл, түүний хэтрэлт хэмнэлтийн шалтгаан бодитой, үнэн зөв эсэх?</p> <p>3.2 Батлагдсан төсвийг холбогдох хууль, эрхийн актын хүрээнд, зориулалтын дагуу зарцуулсан эсэх?</p> <p>3.3 Төсвийг зарцуулахдаа ТБОНӨХБАУХА тухай хуулийг хэрэгжүүлж байгаа эсэх?</p> <p>БҮЛЭГ 4. ТЕЗ-ЫН ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭХ ҮР ДҮН, ЗОРИЛТОТ ТҮВШИНД НИЙЦСЭН ҮҮ?</p> <p>4.1 ТЕЗ-ын хэрэгжүүлж буй хөтөлбөр арга хэмжээний чанарын болон тоон үзүүлэлт зохистой байж чадсан эсэх?</p> <p>4.2 ТЕЗ-д 2018 оны батлагдсан хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлж, төсвийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх?</p> <p>4.3 Хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтэд тавих дотоод хяналт үр дүнтэй байгаа эсэх?</p> <p>Аудитын дүгнэлт Зөвлөмж Тайлангийн төсөлд ирүүлсэн санал, шийдвэрлэлт Хавсралтууд</p>
--	---

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ИТХ	иргэдийн Төлөөлөгчийн Хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНТБ	Орон нутгийн төсвийн байгууллага
ТЗШБ	Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ШХА	Шууд худалдан авалт
ХА	Харьцуулалтын арга
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
АТӨЯХАТ	Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар
ҮХХАТ	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар
ХБГ	Хүлээгдэж буй гүйцэтгэл
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Аудитын нэр:

2018 оны Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц

2. Аудитын код:

САГ-2018/02-СА

3. Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 15.2 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/125 дугаар тушаалаар батлагдсан Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэв.

4. Аудитын зорилт:

Сэлэнгэ аймгийн 2018 оны орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн явцыг шалгаж, дүгнэлт гарган холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Орон нутгийн төсвийн орлого, зарлагыг бодитой төлөвлөсөн үү?
- Орон нутгийн төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн үү?
- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр дүнтэй зарцуулсан уу?
- ТЕЗ-дын хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, зорилтот түвшинд нийцсэн үү?

5. Аудитын хамрах хүрээ:

Аудитыг Сэлэнгэ аймгийн ИТХ-аас баталсан 2018 оны орон нутгийн төсвийн орлого, зарлагын төлөвлөгөө, төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн тайлан, мэдээ, орон нутгийн төсвөөс санхүүжилт авсан байгууллага, аж ахуйн нэгжийн 2018 оны 9 сарын байдлаарх төсвийн гүйцэтгэлийн мэдээ, санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтууд, холбогдох судалгаа болон бусад баримт материалд тулгуурлан гүйцэтгэв.

6. Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын болон гүйцэтгэлийн аудитын журам, арга зүйг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын судалгаа, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

7. Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, 2018 оны Төсвийн тухай хууль, Татварын багц хуулиуд, аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 34 дүгээр, 2018 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 38 дугаар, 2018 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 46 дугаар тогтоолууд, холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа.

8. Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, үе шатны, чанарын хяналтыг аудитын менежер Б.Батмөнх гүйцэтгэн, аудитор А.Дашбат, Ц.Уртнасан, С.Баасансүрэн, У.Цогт, Ц.Отгонбаяр нар 2018 оны 09 дүгээр сарын 03-ны өдрөөс 11 дүгээр сарын 05-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэв.

Үндсэн мэдээлэл

Сэлэнгэ аймгийн 2018 оны төсвийн орлого нь татварын ба татварын бус орлого, улсын төсвийн санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг, төсөвт байгууллагуудын өөрийн орлого, сумдаас төвлөрүүлэх орлогоос бүрдсэн бөгөөд уг эх үүсвэрээр орон нутгийн төсвийн 52, тусгай шилжүүлгийн 134 байгууллага, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ болон ОНХС зэрэг тусгай сангуудыг санхүүжүүлсэн байна.

Аймгийн 2018 оны төсвийн орлого, зарлагын төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 34 дүгээр тогтоолоор 71,069.9 сая төгрөгөөр төлөвлөж, баталсан байна. Үүнээс: Татварын орлогыг 12,266.4 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 433.0 сая төгрөгөөр, хөрөнгийн орлогыг 26.5 сая төгрөгөөр, тусламжийн орлогыг 57,798.5 сая төгрөгөөр, бусад орлогын эх үүсвэрийг 545.5 сая төгрөгөөр баталсан бол 66,516.8 сая төгрөгийг урсгал зардалд, 4,553.1 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар тусгасан байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 38 дугаар тогтоолоор төсвийн орлого, зарлагад тодотгол хийж, 72,205.4 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2018 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 46 дугаар тогтоолоор төсвийн нийт орлого, зарлагын дүнд өөрчлөлт оруулаагүй боловч орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, ОНХС-аар хийгдэх төсөл арга хэмжээнд өөрчлөлт оруулсан байна.

Бүлэг 1

Орон нутгийн төсвийн орлого, зарлагыг бодитой төлөвлөсөн үү?

Зайлшгүй шаардлага үүсээгүй байхад зардал нэмэгдүүлэх зорилгоор аймаг болон 5 сумдын төсөвт нийт 714.0 сая төгрөгийн орлого нэмэгдүүлэн тодотгосон байна.

1.1 Орон нутгийн төсвийн орлогыг холбогдох хууль эрхийн актуудад нийцүүлэн үндэслэлтэй төлөвлөсөн эсэх?

УИХ-аар хянагдаж ирсэн аймгийн төсвийн орлогыг 1,068.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

1.1.1 Төсвийн тухай хуулийн 57, 58 дугаар зүйлийн 58.2-д заасан нөхцөл, чиг үүрэг, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам", аймгийн 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэл, холбогдох бусад хууль эрх зүйн актуудыг үндэслэн Сэлэнгэ аймгийн 2018 оны төсвийн орлогыг боловсруулжээ.

1.1.2 УИХ-аас 2018 оны аймгийн төсвийн /сумдын төсөв орохгүйгээр/ суурь орлогыг **12,202.9** сая төгрөгөөр, үүнээс татварын орлогыг **11,749.4** сая төгрөгөөр, татварын бус орлогыг **427.0** сая төгрөгөөр, хөрөнгийн орлогыг **26.5** сая төгрөгөөр тус тус хянаж ирүүлсэн байна.

1.1.3 УИХ-аас хянаж ирүүлсэн аймгийн төсвийн орлогыг аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 34 дүгээр тогтоолоор **1,068.5** сая төгрөгөөр нэмэгдүүлэхээр, үүнээс Цемент шохой компаниас олон жил дамжин авч чадаагүй ХХОАТ-ын авлагаас **319.4** сая төгрөг, усны төлбөрийн авлагаас **197.6** сая төгрөг, Орон нутгийн өмчийн газрын өөрийн орлогоос **6.0** сая төгрөг, 2017 оны мөнгөн хөрөнгийн болон ОНХС-ийн зарцуулагдаагүй үлдэгдлээс 545.5 сая төгрөгийг тус тус төвлөрүүлэхээр тооцож, **13,271.4** сая төгрөгөөр баталсан байна.

1.1.4 Улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 6,945.1 сая төгрөгөөр, ОНХС-ийн орлогын шилжүүлгийг 3,838.7 сая төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгийн орлогыг 47,014.7 сая төгрөгөөр тус тус тооцож, Сэлэнгэ аймгийн 2017 оны төсвийн нийт орлогыг **71,069.9** сая төгрөгөөр баталсан байна.

1.1.5 УИХ-аар хянагдаж ирсэн усны төлбөрийн орлого 452.4 сая төгрөгийг 197.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 650.0 сая төгрөгөөр баталсан ч 2018 оны эхний 3 дугаар улирлын байдлаар 162.6 сая төгрөгөөр тасарсан байна.

1.1.6 Сүүлийн 3 жилийн байдлаар УИХ-аар хянагдаж ирсэн усны төлбөрийн орлогыг аймгийн ИТХ-аар хий өсгөн төлөвлөсөн нь гүйцэтгэлээр биелэдэггүй атал нэмж баталсан хэмжээгээр аймгийн ИТХ, ЗДТГ, Засаг даргын нөөц сангийн зардлыг өсгөж төлөвлөдөг зөрчил 2018 онд ч давтагдан гарсан байна.

1.1.7 Хөтөлийн цемент шохой ХК-аас авах урьд онуудын ХХОАТ-ын авлага гэж **319.4** сая төгрөгийг тусад нь төсвийн орлогын зүйл болгон баталсан нь *Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь заалттай* нийцэхгүй байна. /

1.1.8 Сумдын орлогын хувьд Сангийн яамнаас ирүүлсэн хязгаараас нэмэгдүүлээгүй ч зарим сумдын хувьд сүүлийн 3 жилийн дундаж орлогын гүйцэтгэлээс огцом өөрчлөлт оруулж баталжээ. Үүнд:

- Сүхбаатар сумын орлогыг 487.9 сая төгрөгөөр өсгөж;
- Ерөө сумын орлогыг 411.9 сая төгрөгөөр;
- Мандал сумын орлогыг 533.9 сая төгрөгөөр;
- Сайхан сумын орлогыг 90.1 сая төгрөгөөр;
- Хүдэр сумын орлогыг 1,338.0 сая төгрөгөөр;
- Шаамар сумын орлогыг 50.3 сая төгрөгөөр тус тус бууруулан баталсан байна.

Дээрх сумдын орлогын өөрчлөлттэй холбоотойгоор аймгийн төсвөөс санхүүжүүлэх дэмжлэгийг:

- Ерөө сум 198.8 сая төгрөг / 2016, 2017 онд санхүүгийн дэмжлэг аваагүй/;
- Мандал сум 356.8 сая төгрөг / сүүлийн 3 жилийн дунджаас 50.0 сая төгрөгөөр бууруулсан/;
- Сайхан сум 393.3 сая төгрөг, / сүүлийн 3 жилийн дунджаас 82.2 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн/;
- Хүдэр сум 142.8 сая төгрөг / сүүлийн 3 жил санхүүгийн дэмжлэг аваагүй/;
- Шаамар сум 454.4 сая төгрөг / сүүлийн 3 жилийн дунджаас 74.6 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн/;
- Сүхбаатар сум 4.6 сая төгрөгөөр /өмнөх 3 жилийн дунджаас 426.7 сая төгрөгөөр буурсан/ тус тус баталсан байна.

1.2 Орон нутгийн төсвийн зарлагыг холбогдох хууль эрхийн актуудад нийцүүлэн үндэслэлтэй төлөвлөсөн эсэх?

УИХ-аар хянагдаж ирсэн аймгийн ИТХ-ын урсгал зардлыг 2.6 дахин нэмэгдүүлэн баталсан байна.

1.2.1 2018 оны аймгийн төсвийн зарлагыг ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 34 дүгээр тогтоолоор **71,069.9** сая төгрөгөөр төлөвлөж, баталсан байна.

1.2.2 УИХ-аас хянагдаж ирсэн орлогыг аймгийн ИТХ-аар **1,068.5** сая төгрөгөөр нэмж баталсантай холбоотойгоор аймгийн ИТХ-ын урсгал зардлыг 238.5 сая төгрөгөөр, аймгийн ЗДТГ-ын зардлыг 80.0 сая төгрөгөөр, Засаг даргын үйл ажиллагааны болон аймгийн хөтөлбөрийн хэрэгжилтийн зардлыг 292.0 сая төгрөгөөр, цаг агаарт зориудаар нөлөөлөх зардлыг 30.0 сая төгрөгөөр, Орон нутгийн өмчийн газрын зардлыг 6.0 сая төгрөгөөр, гэрэлтүүлгийн зардлыг 54.5 сая төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн санд олгох

санхүүжилтийг 45.5 сая төгрөгөөр, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг 40.0 сая төгрөгөөр, сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг 282.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, баталсан байна.

1.2.3 УИХ-ын “Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 2017 оны 29 дүгээр тогтоолоор төсвийн зардлыг хэмнэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээ авахыг бүх шатны төсвийн төсвийн захирагч нарт үүрэг болгосон байдаг. Үүнд:

- Төрийн албаны орон тоо, албан хаагчдын цалин, хөлсийг 2017-2018 онд одоогийн түвшинд хэвээр хадгалах буюу царцаах, албан тушаалын зэрэглэл, цалингийн шатлал ахиулахыг 2017-2019 онд түр зогсоох гэж заасан ч Санхүүгийн хяналт, аудитын албаны орон тоо өмнөх оноос нэмэгдээгүй хэвээр байхад цалин, нийгмийн даатгалын шимтгэлийг 12.7 сая төгрөгөөр нэмж баталсан.
- Төсвийн хөрөнгөөр автомашин шинээр худалдан авахгүй байх гэсэн заалтыг зөрчиж 2018 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 38 дугаар тогтоолоор батлагдсан тодотгоолоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр аймгийн ИТХ-ын ажлын албанд авто машин авахад 15.0 сая төгрөг, аймгийн ЗДТГ-т 2 авто машин авахад 35.0 сая төгрөг, Орхон сумын Засаг даргад авто машин авахад 20.0 сая төгрөг, Сант сумын Засаг даргад авто машин худалдан авахад 15.0 сая төгрөг, Номгон тосгоны Захирагчийн албанд авто машин худалдан авахад 15.0 сая төгрөг, ОНХС-ийн санхүүжилтээр биеийн тамир спортын газарт автобус авахад 28.0 сая төгрөгийг тус тус баталсан байна.

1.2.4 Төсвийн тухай хуулийн 29.4-д “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэж заасныг зөрчин зураг, төсөв хийгдээгүй **762.5** сая төгрөгийн төсөл, арга хэмжээг орон нутгийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр баталсан байна. Үүнд:

- Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Хэрх тосгоны халаалтын төвд өргөтгөл хийх 80.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээ;
- ОНХС-ийн хөрөнгөөр Мандал сумын Нэгдсэн эмнэлэгт хүчил төрөгчийн цогц систем суурилуулах 150.0 сая төгрөг, Тарни багт соёлын төвийн завсар 45.5 сая төгрөг, Түнхэл тосгоны спорт заал, соёлын төвд агааржуулалтын систем суурилуулах 45.0 сая төгрөг, Түнхэл тосгонд хайрган хучилттай зам тавих 94.0 сая төгрөг, Биеийн тамир спортын газарт автобус худалдан авах 28.0 сая төгрөг зэрэг нийт 362.5 сая төгрөгийн 6 төсөл арга хэмжээ;
- Замын сангийн хөрөнгөөр 320.0 сая төгрөгийн 16 төсөл арга хэмжээ.

1.2.5 Төсвийн тухай хуулийн 6.6.6 дахь “Тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх” гэсэн заалтыг зөрчин аймаг, сумын төсвөөс улсын төсвийн байгууллагуудын урсгал болон хөрөнгө худалдан авах зардалд нийт **183.1** сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөсөн байна. Үүнд:

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар:

- Мандал сумын Цагдаагийн байрны сантехник, байрны засварын ажилд **24.0** сая төгрөг.
- Хилийн цэргийн 0101 дүгээр ангийн харуулын байрны засварт **40.0** сая төгрөг.
- Хилийн цэргийн 0243 дугаар ангийн харуулын байрны засварт **15.0** сая төгрөг.

Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар:

- **Мандал сум:** Цагдаагийн хэлтэст автомашин худалдан авахад **31.0** сая төгрөг, Цаг уурын албанд харуулын байр барих, халаалт, цэвэр бохир усны шугамын угсралтын засварт **15.0** сая төгрөг, Шүүхийн шинжилгээний хэсэгт компьютер, принтер худалдан авахад **2.4** сая төгрөг, Нэгдсэн эмнэлэгт 6 ажил, арга хэмжээнд нийт **37.2** сая төгрөг;
- **Баянгол сум:** Цагдаагийн хэсэгт торгуулийн хар машин худалдан авахад **9.8** сая төгрөг;
- **Жавхлант сум:** Цагдаагийн хэсэгт торгуулийн хар машин худалдан авахад **3.7** сая төгрөг, Цагдаагийн кабоны халаалтын засварын зардалд **5.0** сая төгрөг.

1.2.6 Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд хэрэгжих нийт 68 төсөл, арга хэмжээний 14-г нь шууд худалдан авалтын арга, 45-г нь харьцуулалтын арга, 9-г нь нээлттэй тендерийн аргаар сонгон шалгаруулах босго үнэнд багтаан төлөвлөсөн бөгөөд нэгтгэж, нэг багц болгон төлөвлөж, хэрэгжүүлэх боломжтой дараах төсөл, арга хэмжээг салгаж төлөвлөсөн байна. Үүнд:

- Цагааннуур сумын сургуулийн 1, 2 дугаар байрны камержуулалтын ажилд тус бүр **6.0** сая төгрөгийг,
- Цагааннуур сумын хичээлийн А байрны засварын ажилд **7.0** сая төгрөгийг, самбарын засвар, тохижилтын ажилд **5.0** сая төгрөгийг, /1 компаниар гүйцэтгүүлсэн/;
- Алтанбулаг суманд цэнгэлдэх хүрээлэн барих ажилд **80.0** сая төгрөгийг, морь барианы талбай барих ажилд **20.0** сая төгрөгийн ажлыг /1 компаниар гүйцэтгүүлсэн/;
- Орхонтуул сумын ЗДТГ, соёлын төвийн дээвэр засвар **65.0** сая төгрөгийг, сантехникийн засварын ажилд **24.0** сая төгрөгийн /1 компаниар гүйцэтгүүлсэн/ ажлууд зэрэг болно.

1.2.7 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад хөрөнгө оруулалтын шинж чанартай бус тухайн байгууллагын урсгал зардалд тусган, хэрэгжүүлэх боломжтой нийт **23.3** сая төгрөгийн төсөл, арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлсэн нь хөрөнгө оруулалтын зардлын үр нөлөөг бууруулснаас гадна Төсвийн тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 4.1.24-д “Хөрөнгө оруулалт гэж ..., тухайн байгууллагын өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг хэлнэ” гэж заасныг зөрчсөн байна. Үүнд:

- Мандал сумын Нэгдсэн эмнэлгийн засварын ажилд **10.0** сая төгрөг;
- Хаданхүй өрхийн эмнэлгийн өрөөний засварын ажилд **4.9** сая төгрөг, /гүйцэтгэлээр хэрэгжээгүй/;
- Зүүнбүрэн соёлын төвийн дээврийн засварын ажилд **2.4** сая төгрөг;
- Цагааннуур сумын ЗДТГ-ын автомашины засварт **6.0** сая төгрөг.

1.2.8 Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тушаалаар “Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг аймагт 10.0 (арван) сая төгрөг, суманд 5.0 (таван) сая төгрөг байхаар тус тус тогтоож, баталсугай” гэж заасныг зөрчин баяр, наадмын зардлыг жишиг хэмжээнээс **55.7** сая төгрөгөөр хэтрүүлэн баталж, санхүүжүүлсэн байна.

1.3 Төсвийн жилийн дундуур орон нутгийн төсөвт тодотгол хийгдсэн эсэх?

Тайлант оны 3-р улирлын байдлаар аймгийн төсөвт 1 удаа, сумдын төсөвт 1-2 удаа тодотгол хийгдсэн байна.

1.3.1 Аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 34 дүгээр тогтоолоор аймгийн төсвийн / сумд ороогүй / орлого, зарлагыг анх **71,069.9** сая төгрөгөөр баталсан бол 2018 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 38 дугаар тогтоолоор **72,205.4** сая төгрөг болгож тодотгон баталсан байна.

1.3.2 Аймгийн төсөвт хийгдсэн тодотголоор орлого, зарлагыг **1,135.5** сая төгрөгөөр нэмэгдүүлсэн бөгөөд орлого талд гарсан өөрчлөлтүүдийг дурдвал:

- Урьд оны мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 926.0 сая төгрөг;
- Татварын буцаан олголтын хэмнэлт 102.0 сая төгрөг;
- Тусгай зориулалтын шилжүүлэг 7.5 сая төгрөг;
- Хөтөлийн цемент шохой ХК-аас авах ХХОАТ-ын авлага 100.0 сая төгрөгийг цементээр авахаар орлого нэмэгдүүлсэн.

Зарлага талд гарсан өөрчлөлтүүдийг дурдвал:

- Аймгийн ИТХ-ын мэдээлэл сурталчилгааны зардалд 10.0 сая төгрөг, үр дүнгийн урамшууллын зардалд 3.1 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 50.0 сая төгрөг зэрэг нийт **63.1** сая төгрөг;
- Аймгийн ЗДТГ-ын үр дүнгийн урамшууллын зардалд 29.6 сая төгрөг, түлш халаалтын зардалд 55.1 сая төгрөг, урсгал засварын зардалд 51.2 сая төгрөг, бусад зардалд 16.8 сая төгрөг зэрэг нийт **152.7** сая төгрөг;
- Аймгийн БОАЖГ-ын үр дүнгийн урамшууллын зардалд **9.4** сая төгрөг;
- Аймгийн Орон нутгийн өмчийн газрын үр дүнгийн урамшууллын зардалд **2.9** сая төгрөг;
- Санхүүгийн хяналт, аудитын албаны үр дүнгийн урамшууллын зардалд **2.7** сая төгрөг;
- Аймгийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах зардалд **56.7** сая төгрөг;
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын зардалд **740.5** сая төгрөг;
- Сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг **100.0** сая төгрөгөөр;
- Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын урсгал зардлыг **7.5** сая төгрөгөөр тус тус нэмж тодотгосон байна.

1.3.3 Үүнээс зайлшгүй шаардлага үүсээгүй байхад аймгийн төсвийн орлогыг “Хөтөлийн цемент шохой” ХК-аас авах **100.0** сая төгрөгийн ХХОАТ-ын авлагаар нэмэгдүүлэн тодотгож, хөрөнгө оруулалтын зардалд хуваарилан баталсан нь *Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2* дахь заалтыг зөрчсөн байна.

1.3.4 Тайлант оны 3-р улирлын байдлаар аймгийн төсөвт 1, сумдын төсөвт 1-2 удаа тодотгол хийгдсэнээр 2018 оны орон нутгийн нийт орлого, зарлагын төлөвлөгөөг **79,496.2** сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

1.3.5 Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалтыг зөрчин зайлшгүй шаардлага үүсээгүй байхад зарлагыг нэмэгдүүлэх зорилгоор сумдын төсөвт нийт **614.0** сая төгрөгийн /дэлгэрэнгүйг Хавсралт № 1-д харуулав/ тодотгол хийсэн байна.

1.3.6 17 сум тус бүр 1-2 удаа тодотгол хийсэн бөгөөд Мандал, Сүхбаатар, Алтанбулаг, Баянгол, Сайхан сумд төлөвлөгөөнөөс давсан орлогыг /урьд оны үлдэгдэл ороогүй/ тодотгон, орон нутгийн байгууллагуудын урсгал зардалд 146.0 сая төгрөгийг, хөрөнгө оруулалтын зардалд 469.5 сая төгрөгийг санхүүжүүлэхээр баталсан байна.

1.3.7 Орон нутгийн /аймаг, сумд нийлээд/ нийт төсвийн өөрчлөлтийг хүснэгтээр харуулбал:

Аймаг, сумдын төсөвт хийсэн тодотгол

Хүснэгт №1 /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Сангийн яамны хянасан дүн	2018 он			
			Анх батлагдсан	Тодотгол-1	Тодотгол-2	Тодотгол-3
А	Б	1	2	3	4	5
1	ИТХ-ын шийдвэрийн огноо, дугаар	2017.11.15	2017-12-01 №34	2018-04-05 №38		
2	ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН СУУРЬ ОРЛОГО	70,118.7	77,159.0	79,496.2	-	-
3	НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	70,118.7	77,159.0	79,496.2	-	-
4	УРСГАЛ ОРЛОГО	15,929.9	16,371.9	17,349.1	-	-
5	Татварын орлого	14,714.4	14,895.6	15,621.0		
6	Татварын бус орлого	1,215.5	1,215.6	1,382.8		
7	ХӨРӨНГИЙН ОРЛОГО	26.5	26.5	26.5		
8	ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	53,959.8	60,215.1	60,272.8		
9	БУСАД ЭХ ҮҮСВЭР					
10	БАЙГУУЛЛАГЫН ӨӨРИЙН ОРЛОГО	202.5	260.7	345.3		
11	ТУСЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО		-	-		
12	ӨМНӨХ ОНЫ ҮНДСЭН ТЭНЦЛИЙН АШИГ /өмнөх оны давсан орлогоос, хэмнэгдсэн зардлаас, мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс/		545.5	1,847.8		
13	ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН СУУРЬ ЗАРЛАГА	70,118.7	77,159.0	79,496.2	-	-
14	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	70,118.7	77,159.0	79,496.2	-	-
15	УРСГАЛ ЗАРДАЛ	66,873.2	69,354.3	70,195.9	-	-
16	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	53,383.8	56,044.9	57,989.0		
17	ХҮҮ		-	-		
18	ТАТААС	539.6	539.4	508.2		
19	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,949.8	12,770.0	11,698.8		
20	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,245.5	6,810.0	8,281.0		
21	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ		994.7	1,019.3		
22	УРСГАЛ ТЭНЦЭЛ	- 37,993.5	- 40,212.4	- 41,148.0	-	-
23	НИЙТ ТЭНЦЭЛ	-	-	(0.0)		
24	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-	-		
25	1. Мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт		-	-		
26	2. Өмнөх оны үлдэгдлээс санхүүжих		545.5	1,847.8		
27	3. Бусад		-	-		

Бүлэг 2

Орон нутгийн төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн үү?

Орон нутгийн төсвийн нийт урсгал орлогын төлөвлөгөө ХБГ-ээр 7.5 хувиар тасрах төлөвтэй байна.

2.1 Татварын ба татварын бус орлогыг нэмэгдүүлэх нөөц боломжийг бүрэн ашигласан эсэх?

Аймаг, сумдын өмнөх онуудын татварын авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

2.1.1 Аймаг, сумдын орон нутгийн төсвийн урсгал орлого 17,230.2 сая төгрөгөөр батлагдсанаас аймгийн Татварын хэлтсийн тооцсон ХБГ-ээр 15,944.5 сая төгрөгийн буюу 92.5 хувийн гүйцэтгэлтэй гарах төлөвтэй байна.

Аймаг, сумдын төсвийн орлого / ХБГ-ээр/

Хүснэгт №2 /сая төгрөг/

Орлогын нэр төрөл	Өмнөх он	Тайлант оны ХБГ үйцэтгэл							
		Аймгийн орлого		Сумдын орлого		Төсвийн нийт орлого			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл /ХБГ үйц/	Төлөвлөгөө	Гүйцэтгэл /ХБГ үйц/	Төлөвлөгөө	Гүйцэтгэл /ХБГ үйц/	Зөрүү	Хувь
Урсгал орлого	23,638.5	12,901.3	11,261.1	4,302.4	4,656.9	17,203.7	15,918.0	(1,285.7)	92.5
Татварын орлого	21,102.3	12,468.3	10,659.4	3,152.7	3,108.8	15,621.0	13,768.2	(1,852.8)	88.1
Хүн амын орлогын албан татвар	11,523.5	11,013.7	9,367.6	1,418.2	1,412.9	12,431.9	10,780.5	(1,651.4)	86.7
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(1,116.0)	(1,148.0)	(1,148.0)			(1,148.0)	(1,148.0)	-	100.0
Өмчийн татвар	1,007.4	860.0	847.7	51.8	37.2	911.8	884.9	(26.9)	97.0
Бараа үйлчилгээний албан татвар	9,687.4	1,742.6	1,592.1	1,682.7	1,658.7	3,425.3	3,250.8	(174.5)	94.9
Татварын бус орлого	2,536.2	433.0	601.7	1,149.7	1,548.1	1,582.7	2,149.8	567.1	135.8
Татварын бус орлого	2,275.4	380.0	537.8	1,002.8	1,369.9	1,382.8	1,907.7	524.9	138.0
Өөрийн орлого	260.8	53.0	63.9	146.9	178.2	199.9	242.1	42.2	121.1
Хөрөнгө борлуулсны орлого	53.5	26.5	26.5			26.5	26.5	-	100.0
НИЙТ ОРЛОГО	23,692.0	12,927.8	11,287.6	4,302.4	4,656.9	17,230.2	15,944.5	-1,285.70	92.54

2.1.2 Дээрх хүснэгтээс харахад хүн амын орлогын албан татвар 1,651.4 сая төгрөгөөр, өмчийн татвар 26.9 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний албан татвар 174.5 сая төгрөгөөр тасрах төлөвтэй байгаа бол татварын бус орлого 524.9 сая төгрөгөөр, төсөвт байгууллагуудын өөрийн орлого 42.2 сая төгрөгөөр тус тус давж биелэх төлөвтэй харагдаж байна.

2.1.3 Аймгийн төсвийн орлогын хувьд ХХОАТ-ын орлого **1,651.4** сая төгрөгөөр, ус ашигласны төлбөрийн орлого **162.6** сая төгрөгөөр тасрах төлөвтэй байна. Орлого тасрах гол шалтгааныг тодруулбал:

- “Бороо гоулд” ХХК-ийн үйл ажиллагаа зогссон.
- Анхны төсөв батлах үед 2018 онд Баянгол, Ерөө, Хүдэр, Орхонтуул, Сайхан сумдад цемент үйлдвэрлэх, төмрийн хүдэр болон алт угаах зориулалтаар үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудаас нийт 6874,0 метр куб ус ашиглахаар тооцоо гаргасан ч дээрх газруудаас тооцоолсон хэмжээний орлого төвлөрөөгүй.

2.1.4 Сумдын орлогын хувьд 6 сумын төлөвлөгөө 2.6-93.6 хувиар давж , бусад 11 сумын төлөвлөгөө 0.6-42.6 хувиар тасарснаас нийт сумдын дүнгээр 7.8 хувиар давж биелэх төлөвтэй байна.

Сумдын орлогын ХБГ, санхүүгийн дэмжлэг


Хүснэгт №3

/төсөвт байгууллагын өөрийн орлого ороогүй /сая төгрөгөөр/

д/д	Сумдын нэр	Орлого				Санхүүгийн дэмжлэг
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл /ХБГүйц/	Биелэлт /%/	Зөрүү	
1	Алтанбулаг	429.9	427.3	99.4	(2.6)	73.1
2	Баруунбүрэн	94.1	84.6	89.9	(9.5)	318.3
3	Баянгол	134.5	193.1	143.6	58.6	342.5
4	Ерөө	368.6	439.5	119.2	70.9	202.3
5	Хүдэр	180.7	242.3	134.1	61.6	143.3
6	Хушаат	57.9	51.7	89.3	(6.2)	253.5
7	Жавхлант	39.9	36.1	90.5	(3.8)	307.4
8	Мандал	1,044.2	1,071.4	102.6	27.2	359.3
9	Орхон	44.2	66.4	150.2	22.2	279.2
10	Орхонтуул	74.4	56.2	75.5	(18.2)	361.6
11	Сайхан	297.6	576.2	193.6	278.6	394.8
12	Сант	41.1	23.6	57.4	(17.5)	264.7
13	Шаамар	63.1	53.0	84.0	(10.1)	477.6
14	Сүхбаатар	1,051.8	975.3	92.7	(76.5)	5.1
15	Цагааннуур	77.2	55.1	71.4	(22.1)	334.0
16	Түшиг	112.5	88.6	78.8	(23.9)	205.0
17	Зүүнбүрэн	43.8	38.3	87.4	(5.5)	330.9
	Дүн	4,155.5	4,478.7	107.8	323.2	4,652.6

2.1.5 Орлого давж биелсэн сумдын орлого, санхүүгийн дэмжлэгийн 2018 оны 09 дүгээр сарын 30-наарх бодит гүйцэтгэлийг графикаар харуулбал:

График №1 /сая төгрөг/



Дээрх графикаас дүгнэхэд аймгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг авахаар төлөвлөгдсөн 5 сумын төлөвлөгөөнөөс давсан орлого болох 491.9 сая төгрөгөөр аймгийн төсвийн зарлагыг бууруулах боломжтой юм.

2.1.6 2018 оны 3-р улирлын байдлаар сумдын орлогын төлөвлөгөөний биелэлтийг нэр төрлөөр нь авч үзэхэд хог хаягдлын хураамж 26.4 сая төгрөгөөр, үйл ажиллагааны албан татварын орлого 23.3 сая төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлого 91.6 сая төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого 32.6 сая төгрөгөөр, хүү торгуулийн орлого 389.8 сая төгрөгөөр тус тус давж биелсэн бол хөрөнгийн орлого 41.6 сая төгрөгөөр, бууны албан татвар 14.6 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамжийн татвар 11.4 сая төгрөгөөр, ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлого 27.2 сая төгрөгөөр, нэр зааж ангилагдаагүй бусад орлого 25.3 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Зарим сумдын төлөвлөгөөнөөс давсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

- **Баянгол сум:** Хүү торгуулийн орлогод Зөрчлийн тухай хуулийн дагуу Цагдаагийн тасгаас төвлөрүүлсэн торгуулийн орлого болон Замын цагдаагийн тасгаас зохион байгуулсан аяны хүрээнд жолооны дүрэм зөрчигсдөөс төвлөрүүлсэн торгуулийн орлого орсон,
- **Ерөө сум:** Хүү торгуулийн орлогод 1 удаагийн шинжтэй байгаль орчны нөхөн төлбөрийн орлого орсон;
- **Хүдэр сум:** Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогод самрын орлого орж давсан, хүү торгуулийн орлогод Зөрчлийн тухай хуультай холбоотой цагдаагийн торгууль болон байгаль орчны байцаагчдын тавьсан торгуулийн орлогууд орсон;
- **Мандал сум:** Хөрөнгийн орлогод хадгаламжийн хүүгийн орлого орсон, хүү торгуулийн орлогод цагдаагийн торгууль болон шүүхээс тавьсан 1 удаагийн шинжтэй торгуулиуд орсон;

- **Сайхан сум:** Хөрөнгийн орлогод хадгаламжийн хүүгийн орлого орсон, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогод татварын байцаагчдаас Цемент шохой компанид тавьсан торгууль орсон /1удаагийн шинжтэй/,

2.1.7 Татварын орлогын өмнөх онуудын дутуу төлөлтийн судалгааг нэр төрлөөр гаргаж хүснэгтээр харуулбал:

Аймаг, сумдын татварын авлагын судалгаа

Хүснэгт №4 /сая төгрөг/

№	Татварын нэр төрөл	Өмнөх онуудын татварын авлага
Аймгийн татварын орлого		
1	Цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын албан татвар	4,210.8
2	АТӨЯХАТ	29.9
3	Газрын төлбөр	388.5
4	ҮХХАТ	620.3
5	Улсын тэмдэгтийн хураамж	3.8
6	Усны төлбөр	9.2
Авлагын дүн		5,262.5
Сумын татварын орлого		
2	Ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж, ашигласны төлбөр	8.6
3	Татварын хүү, алдангийн орлого	50.0
4	Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	87.0
5	Ус, рашаан ашигласны төлбөр	201.1
6	ХХОАТ-ын тухай хуулийн 8.1.1-д зааснаас бусад орлого	103.1
7	Иргэдийн хадгаламжийн хүүгийн орлого	5.7
Авлагын дүн		455.5
Орон нутгийн нийт авлагын дүн		5,718.0

Дээрх тооцооллоос харахад аймаг, сумдын ТЕЗ, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, холбогдох мэргэжлийн байгууллагууд хамтарч өмнөх онуудын дутуу төлөлттэй байгаа татварын орлогуудыг төвлөрүүлэх тал дээр тодорхой арга хэмжээ авч, барагдуулж ажиллавал аймгийн төсвийн орлогыг **5,262.5** сая төгрөгөөр, сумдын орлогыг **455.5** сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломж харагдаж байна.


2.2 Төсөвт байгууллагуудын өөрийн орлогыг нэмэгдүүлэх нөөц боломж байсан эсэх?

Орон нутгийн өмч ашиглан халаалтын үйлчилгээ үзүүлж буй хувийн компаниудаас 138.7 сая төгрөгийн түрээсийн орлого төвлөрүүлэх нөөц боломжийг алдсан байна.

2.2.1 Тайлант оны 3-р улирлын байдлаар орон нутгийн төсөвт байгууллагууд өөрийн орлогын төлөвлөгөөг 27.3 хувиар буюу 41.6 сая төгрөгөөр давуулсан бол тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд өөрийн орлогын төлөвлөгөөг 14.5 хувиар буюу 17.1 сая төгрөгөөр тасалсан байна.

**Орон нутгийн болон тусгай шилжүүлгийн байгууллагуудын
2018 оны 3-р улирлын байдлаарх өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл**

График №2 /сая төгрөгөөр/



2.2.2 Тайлант оны 3-р улирлын байдлаар орон нутгийн байгууллагуудын өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг авч үзвэл:

- Мандал сумын ойн анги, Цагааннуур сумын ойн анги, ЗДТГ, Орхонтуул сумын ЗДТГ, Шаамар сумын ЗДТГ, Дулаанхаан тосгоны Захирагчийн алба зэрэг байгууллагууд төлөвлөгөөг **1.7-8.9** дахин давуулан биелүүлсэн;
- Баянгол сумын ЗДТГ, Баруунбүрэн сумын ойн анги, Жавхлант сумын ЗДТГ зэрэг байгууллагууд төлөвлөгөөг **14.9-30.9** хувиар тасалсан;
- Ерөө, Сант сумын ЗДТГ –ууд төлөвлөсөн өөрийн орлогыг огт төвлөрүүлээгүй байна. /Дэлгэрэнгүй судалгааг Хавсралт №2-т үзүүлэв/

2.2.3 Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын хувьд:

- Цагааннуур сумын Биеийн тамир спорт цогцолбор, Хэрх тосгоны Соёлын төв зэрэг байгууллагууд төлөвлөгөөг **2.0-4.8** дахин давуулан биелүүлсэн;
- Мандал сумын биеийн тамир спорт сургалтын цогцолбор, Баянгол сумын Соёлын төв, Орхонтуул сумын Соёлын төв, Хушаат сумын ЕБС, Бугант тосгоны Соёлын төв, Түнхэл тосгоны Соёлын төв, Сэлэнгийн долгио чуулга, Сүхбаатар сумын Спорт сургууль зэрэг байгууллагууд төлөвлөгөөг **32.0-95.1** хувиар тасалсан байна;
- Орхон сумын Соёлын төв, Түшиг сумын ЕБС төлөвлөсөн өөрийн орлогыг төвлөрүүлээгүй байна. /Дэлгэрэнгүйг Хавсралт №3-т үзүүлэв/

2.2.4 Сумдын төр, төсвийн байгууллагуудад халаалтын үйлчилгээ үзүүлж буй хувийн компаниуд орон нутгийн өмчийн барилга, байгууламжийг ашиглан, үйл ажиллагаа явуулж байгаа боловч Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 28 дугаар зүйлийн 28.5-д заасны дагуу түрээсийн төлбөр төлж байгаагүй бөгөөд аймгийн ТЭЗ-ийн 2017 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 119 дүгээр тогтоолоор батлагдсан түрээсийн төлбөрийн жишиг үнийн дагуу түрээсийн орлогын тооцооллыг хийж, **138.7** сая төгрөг төвлөрүүлэх боломжтой болохыг

тооцож, 2018 онд дээрх орлогыг төвлөрүүлэх зөвлөмж өгсөн ч өнөөг хүртэл хэрэгжүүлээгүйгээс уг эх үүсвэрээр орлого төвлөрүүлээгүй байна.

Халаалтын компаниудад орон нутгийн өмч ашиглуулсны түрээсээс төвлөрүүлэх орлогын судалгаа

Хүснэгт № 5 /сая төгрөг/

№	Сумын нэр	Халаалтын компанийн нэр	Халаалтын компанийн ашиглаж байгаа объект аль байгууллагын бүртгэлд байдаг талаар	Талбайн хэмжээ /М2/	м2-н үнэ /төгрөгөөр/	Түрээсийн орлого /сая төгрөг/	Нэмэгдүүлэх боломжтой орлогын дүн /7 сар төлөхөөр/
1	Баянгол	Ануужээ ХХК	ЗДТГазар	750	5000	3.8	26.3
2	Ерөө	Монжим ХХК	ЗДТГазар	15	5000	0.1	0.5
		Монжим ХХК	ЕБСургууль	135	5000	0.7	4.7
		Монжим ХХК	Цэцэрлэг	21.4	5000	0.1	0.7
		Монжим ХХК	Соёлын Төв, спорт цогцолбор	30	5000	0.2	1.1
		Монжим ХХК	ЭМТөв	36	5000	0.2	1.3
		Ерөө сум нэгтгэл				4.9	34.6
3	Жавхлант	Монжимтрейд ХХК	ЗДТГазар	20	5000	0.1	0.7
		Монжимтрейд ХХК	Дунд сургууль	58	5000	0.3	2.0
		Монжимтрейд ХХК	Цэцэрлэг	42	5000	0.2	1.5
		Монжимтрейд ХХК	Соёлын төв	30	5000	0.2	1.1
		Монжимтрейд ХХК	ЭМТөв	10	5000	0.1	0.4
		Жавхлант нийт дүн				0.8	5.6
4	Зүүнбүрэн	Монжим ХХК	Орон нутгийн өмч	55	5000	0.3	1.9
5	Мандал	Арвижих өргөө ХХК	Хэрх соёлын төв	152	5000	0.8	5.3
		Хэрх илч ХХК	Хэрх захирагчийн алба	500	5000	2.5	17.5
		Түнхэл дулаан ХХК	Түнхэл захирагчийн алба	112.5	5000	0.6	3.9
		Мандал сум нэгтгэл				3.8	26.8
6	Сант	Бүрэндуглаан	ЕБСургууль	54	5000	0.3	1.9
7	Цагааннуур	Атар трейд ХХК	Сумын ЗДТГ	174.6	5000	0.9	2.4
8	Хушаат	Монжим ХХК	ЗДТГазар	78.4	5000	0.4	2.7
		Монжим ХХК	ЕБСургууль	65	5000	0.3	2.3
		Монжим ХХК	ЭМТөв	27.04	5000	0.1	0.9
		Монжим ХХК	Цэцэрлэг	30.8	5000	0.2	1.1
		Монжим ХХК	Соёлын төв	24.7	5000	0.1	0.9
		Хушаат сум нэгтгэл				2.3	15.9
9	Хүдэр	Хүдэр дулаан	ЗДТГазар	288	5000	1.4	10.1
10	Шаамар	Алтанбилэг	Шаамар сум	180	5000	0.9	6.3
		Алтанбилэг	Дулаанхаан тосгон	200	5000	1.0	7.0
		Шаамар сум нэгтгэл				1.9	13.3
		Нийт дүн		1,321.6		20.3	138.7

Бүлэг 3

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр дүнтэй зарцуулсан уу?

Засгийн газрын нөөц сангаас олгосон санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулсан байна.

3.1 Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан бодитой, үнэн зөв эсэх?

Орон нутгийн нийт төсвийн зарлага ХБГ-ээр 8.3 хувиар хэмнэгдэх төлөвтэй байна.

3.1.1 Сэлэнгэ аймгийн 2018 оны төсвийн нийт зарлага /аймаг, сумдын нийт дүнгээр/ тодотгосон төсвөөр 79,496.2 сая төгрөгөөр батлагдсанаас аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс ирүүлсэн мэдээ, судалгаагаар 72,921.3 сая төгрөгийн буюу 91.7 хувийн ХБГ-тэй тайлагнагдах төлөвтэй байна.

Нийт зарлагын ХБГ/эдийн засгийн ангиллаар/

Хүснэгт №6 /сая төгрөг/

ТГ-ийн тайлангийн	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2018 он			
			Анх батлагдсан	Тодотгосон төсөв	Урьдчилсан гүйцэтгэл	Зөрүү
А	Б	1	2	3	4	5=4-3
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	76,839.4	77,159.0	79,496.2	72,921.3	- 6,574.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	69,047.6	69,354.2	70,195.9	66,160.7	- 4,035.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	54,922.6	56,044.9	57,989.0	54,838.9	- 3,150.1
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	33,194.2	33,929.4	35,114.4	34,166.3	- 948.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,675.8	4,080.8	4,221.6	4,063.3	- 158.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,430.1	7,942.1	7,876.7	7,365.3	- 511.4
2104	Хангамж, бараа материалын зардал	1,407.2	1,184.5	1,317.2	1,183.1	- 134.1
2105	Нормативт зардал	3,055.5	3,131.7	3,083.3	2,755.1	- 328.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,331.4	405.7	741.3	567.9	- 173.3
2107	Томилолт, зочны зардал	242.9	321.8	315.6	217.8	- 97.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,445.0	1,613.6	1,428.5	1,115.1	- 313.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,140.5	3,435.2	3,890.4	3,404.9	- 485.5
212	ТАТААС	823.7	539.4	508.2	498.9	- 9.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,301.3	12,770.0	11,698.8	10,823.0	- 875.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,331.9	6,810.0	8,281.0	6,429.7	- 1,851.3
220001	Барилга байгууламж	5,032.1	3,964.5	4,210.9	3,156.5	- 1,054.4
221001	Их засвар	1,644.0	1,171.7	1,485.8	1,387.0	- 98.8
222001	Тоног төхөөрөмж	577.3	577.9	852.1	547.6	- 304.5
223001	Бусад хөрөнгө	78.5	1,095.9	1,732.2	1,338.7	- 393.6
224001	Стратегийн нөөц хөрөнгө		-	-		
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	459.9	994.9	1,019.3	331.0	- 688.4

3.1.2 Орон нутгийн төсвийн нийт зарлагыг эдийн засгийн ангиллаар нь задалж үзвэл бараа, ажил үйлчилгээний зардал 94.6 хувийн, татаас 98.2 хувийн, урсгал шилжүүлэг 92.5 хувийн, хөрөнгийн зардал 77.6 хувийн, эргэж төлөгдөх цэвэр зээл 32.5 хувийн гүйцэтгэлтэй буюу хэмнэгдэх төлөвтэй байна.

3.1.3 2018 оны 3-р улирлын байдлаар орон нутгийн төсвийн нийт зарлага /аймаг, сумдын нийт дүнгээр/ 9,012.9 сая төгрөгөөр хэмнэгдэж, 85.6 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.

2018 оны 3-р улирлын байдлаарх төсвийн зарлагын гүйцэтгэл

Хүснэгт №7 /сая төгрөг/

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хэмнэлт/- /,хэтрэлт/+
ОРОН НУТГИЙН НИЙТ ЗАРДАЛ	62,681.1	53,668.2	(9,012.9)
<i>Үүнээс: Бараа ажил үйлчилгээний зардал</i>	<i>42,690.1</i>	<i>39,237.6</i>	<i>(3,452.5)</i>


Татаас	371.4	365.2	(6.2)
Урсгал шилжүүлгийн зардал	10,319.3	8,585.7	(1,733.6)
Хөрөнгийн зардал	8,281.0	5,148.7	(3,132.3)
Төсөл сан	1,019.3	331.0	(688.3)

Их хэмжээний хэмнэлттэй гарсан зардлуудыг задалж, шалтгааныг нь тодруулбал:

- **Цалин, НДШ-ийн зардал:** Багш нарын ажил хаясан хугацааны нэмэгдэл цалинг олгоогүйтэй холбоотой цалин, НДШ-ийн зардал хэмнэлттэй гарсан бөгөөд дээрх хугацааны цалинг олгох шийдвэр холбогдох дээд шатны байгууллагаас ирсэн тохиолдолд гүйцэтгэл гарахаар хүлээгдэж байна.
- **Тогтмол зардал:** Өвөлжилтийн бэлтгэл ажлын хувьд нам даралтын уурын зуухаар халаалт хийдэг зарим байгууллагууд түлшээ худалдан авч амжаагүй байгаатай холбоотой хэмнэлт үүссэн харагдаж байна.
- **Урсгал шилжүүлэг:** Халамжийн зардлыг Төрийн банк, Капитрон банктай байгуулсан гэрээний дагуу сарын эхний 7 хоногт багтаан банк өөрийн эх үүсвэрээс санхүүжүүлж олгодог ба гарсан гүйцэтгэлээр төсвөөс санхүүжилтийг нөхөж олгодог. Үүнтэй холбоотойгоор 3-р улирлын байдлаар халамжийн зардал хэмнэлт үүссэн харагдаж байгаа.
- **Хөрөнгийн зардал:** Тендерийн үйл ажиллагаатай холбоотойгоор хөрөнгө оруулалтын зарим ажлууд оройтож эхэлсэн учир санхүүжилтийг гэрээний дагуу бүрэн олгоогүйгээс хэмнэлт үүссэн. 3-р улирлын байдлаар аймгийн хэмжээнд нийт ажлын 95 хувь орчим нь сонгон шалгаруулалт нь явагдаж дууссан байна.

Орон нутгийн төсвийн нийт зарлагын бүтэц /2018 оны ХБГ-ээр/

График №3 /хувиар/



3.1.4 Графикаас харахад нийт төсвийн зарлагын 52.0 хувийг цалин, шимтгэлийн зардалд, 10.0 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд, 4.0 хувийг нормативт зардалд, 15.0 хувийг урсгал шилжүүлгийн зардалд, 9.0 хувийг хөрөнгийн зардалд, 2.0 хувийг хангамж, бараа материалын зардалд, 8.0 хувийг бусад зардалд зарцуулсан байна.

3.2 Батлагдсан төсвийг холбогдох хууль, эрхийн актын хүрээнд, зориулалтын дагуу зарцуулсан эсэх?

Засгийн газрын нөөц сангаас өвөлжилтийн хүндрэлийг даван туулах зориулалтаар олгосон санхүүжилтийг гадаад арга хэмжээнд зарцуулж, нөхөн бүрдүүлсэн байна.

3.2.1 Засгийн газрын 2018 оны 35 дугаар тогтоолоор өвөлжилтийн байдал хүндэрч буйтай холбоотой урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан Засгийн газрын нөөц сангаас олгосон санхүүжилтээс БНХАУ-ын Гуанжоу хотноо зохион байгуулагдах хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн үзэсгэлэн худалдааны арга хэмжээнд оролцох аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, сумдын Засаг дарга нар 41 хүний зардалд буюу төсөвт тусгагдаж, батлагдаагүй зардалд **50.0** сая төгрөгийг 2018 оны 03 дугаар сарын 16-нд шилжүүлэн зарцуулсан байна.

3.2.2 Дээрх 50.0 сая төгрөгийг зарцуулсны дараа буюу 2018 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн ИТХ-ын 38 дугаар тогтоолоор хийгдсэн төсвийн тодотголд аймгийн ИТХ-ын ажлын албаны урсгал зардалд тусган баталж, аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд 2018 оны 05 дугаар сарын 24-ний өдөр шилжүүлсэн байна.

3.2.3 Аймгийн Засаг даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/543 дугаар захирамжаар “Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах зардлыг зарцуулахад дагаж мөрдөх журам”-ыг баталж, мөрдөн ажиллаж байна.

3.2.4 Аймгийн ИТХ-ын 2018 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 38 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн зардлыг 242.0 сая төгрөгөөр, аймгийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн зардлыг 106.7 сая төгрөгөөр, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийг 217.8 сая төгрөгөөр тус тус тодотгон баталсан байна.

3.2.5 2018 оны 3-р улирлын байдлаар аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 80 ажил, арга хэмжээнд нийт 238.3 сая төгрөг, Засаг даргын үйл ажиллагааны хэрэгжилтийн зардлаас 43 арга хэмжээнд нийт 195.5 сая төгрөг, аймгийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн зардлаас 12 арга хэмжээнд нийт 49.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

3.2.6 “Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах зардлыг зарцуулахад дагаж мөрдөх журам”-ын 4.1-д “Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зардлаас гэнэтийн болон зайлшгүй шаардлагын улмаас заавал шийдвэрлэгдэх хөрөнгийн шинжтэй зардал гаргаж болно” гэж заасан нь тус журмыг батлахад үндэслэл болгосон Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 5.1 дэх “Энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь заалтад зааснаас бусад зориулалтаар Засаг даргын нөөц хөрөнгөөс хөрөнгө оруулалтын

зардал гаргах, олгосон хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахыг хориглоно” гэсэн заалттай зөрчилдөж байна.

3.2.7 Шууд худалдан авах босго үнэд болон журмын 4.2-т заасан шаардлагад нийцүүлэхийн тулд Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн зардлаас аймгийн Нэгдсэн эмнэлэгт шаардлагатай аппарат худалдан авахад **9.8** сая төгрөг, бусад зүйлийг худалдан авахад **4.9** сая төгрөг зэрэг 14,7 сая төгрөгийн хөрөнгийн зардлыг нэг багц болголгүй 2 хувааж санхүүжүүлсэн байна.

3.2.8 Замын сангийн дансанд төвлөрдөг байсан замын хураамжийн орлогыг аймгийн нэр зааж ангилагдаагүй бусад орлогод төвлөрүүлдэг болсонтой холбоотойгоор уг орлого 3-р улирлын байдлаар 69.6 хувиар буюу 117.9 сая төгрөгөөр /*үүнээс: замын хураамжийн орлого 82.8 сая төгрөг/* давж биелсэн байна. Ингэснээр замын хураамжийн орлогыг орон нутгийн чанартай авто замын арчлалт, засварын ажлыг санхүүжүүлэхэд бус бусад урсгал зардалд зарцуулж байгаа нь Авто замын тухай хуулийн 24.3-д “Улсын авто замын сангийн хөрөнгөөр олон улс, улсын чанартай авто замын, нийслэл, орон нутгийн замын сангийн хөрөнгөөр нийслэл, орон нутгийн чанартай авто замын арчлалт, засварын ажлыг тус тус санхүүжүүлнэ” гэж заасныг зөрчиж байна.

3.3 Төсвийг зарцуулахдаа ТБОНӨХБАУХА тухай хуулийг хэрэгжүүлж байгаа эсэх?

ТБОНӨХБАУХА тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.3.1 Аймгийн ИТХ-ын 2018 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 46 дугаар тогтоолоор аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэмнэлт болон “Цагааннуур сумын Эрүүл мэндийн төвд түргэн тусламжийн авто машин худалдан авах” 30.0 сая төгрөгийн ажлуудыг өөрчлөн, нийт **62.7** сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 ажил арга хэмжээг санхүүжүүлэхээр, ОНХС-ийн хөрөнгө оруулалтын хэмнэлтээс аймгийн Нэгдсэн эмнэлгийн поликлиник засварын дүнг **19.8** сая төгрөгөөр, аймгийн баяр наадмын зардлыг **15.7** сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн өөрчлөлт хийсэн байна.

3.3.2 Ингэснээр аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 4,856.1 сая төгрөгийн 71 төсөл, арга хэмжээ, ОНХС-ийн хөрөнгөөр 1,820.5 сая төгрөгийн 28 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Төлөвлөсөн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ

Хүснэгт №8 /сая төгрөг/

	ШХА		ХА		НТШ		Нийт	
	тоо	Батлагдсан төсөв	тоо	Батлагдсан төсөв	тоо	Батлагдсан төсөв	тоо	Батлагдсан төсөв
ХО	14	93.6	46	1,601.8	11	3,160.6	71	4,856.1
ОНХС	3	26.9	19	759.8	6	1,033.7	28	1,820.5

2018 оны 3-р улирлын байдлаар аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийхээр төлөвлөсөн 71 төсөл, арга хэмжээнээс 33-г нь, ОНХС-ийн хөрөнгөөр хийхээр төлөвлөсөн 28 ажлаас 14-г нь бүрэн хэрэгжүүлж, ашиглалтад хүлээн авсан байна.

3.3.3 Тайлант онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн аймгийн хөрөнгө оруулалтын нийт 68 төсөл, арга хэмжээнээс 65 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан бөгөөд 9 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг НТШ-ын, 42 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулж, 14 төсөл арга хэмжээг шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлэхээр төлөвлөсөн байна.

3.3.4 Шууд худалдан авах болон харьцуулалтын аргаар сонгон шалгаруулсан нийт 56 төсөл, арга хэмжээнээс 34 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг аймгийн ОНӨГ, эрх шилжүүлсэн 22 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг Сүхбаатар, Ерөө, Мандал, Зүүнбүрэн, Шаамар, Баруунбүрэн, Орхонтуул, Цагааннуур, Орхон, Сант, Сайхан зэрэг 11 сум, 1 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг “Сэлэнгэ үйлчилгээ” ОНӨААТҮГ, 1 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг Хилийн цэргийн 0243-р анги, 1 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг Хилийн цэргийн 0101-р анги тус тус сонгон шалгаруулж, хэрэгжүүлсэн байна.

3.3.5 Аудитын явцад аймгийн төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудын гэрээний хэрэгжилтийг тулган баталгаажуулахад:

➤ Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын хувьд гэрээний хугацаа хэтрүүлсэн нийт 7 ажлаас Түшиг сумын сургуулийн спорт заалны засварын ажилд хугацаа хэтрүүлсэн хоног тутмын алданги 0.6 сая төгрөгийг тооцсон бол бусад 6 төсөл, арга хэмжээнд нийт **3.8 сая** төгрөгийн алдангийг тооцоогүй байна. Үүнд:

1. Сүхбаатар сумын 3-р цэцэрлэгийн дээврийн засварын ажил - 43 хоногийн алданги 0.2 сая төгрөг;
2. Цагааннуур сумын хичээлийн А байрны самбарын засвар, тохижилт - 12 хоногийн алданги 0.04 сая төгрөг;
3. Алтанбулаг сумын цэнгэлдэх хүрээлэнгийн гадна цахилгааны шугам татах ажил - 62 хоногийн алданги 0.9 сая төгрөг;
4. Сүхбаатар сум 24-р байрны сантехникийн шугам сүлжээний засвар - 20 хоногийн алданги 0.2 сая төгрөг;
5. Багуудад тоног төхөөрөмж авах ажил - 20 хоногийн алданги 0.5 сая төгрөг;
6. Номгон тосгоны соёлын төвийн их засварын ажил - 44 хоногийн алданги 2.0 сая төгрөг.

➤ Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтын хувьд гэрээний хугацаа хэтрүүлсэн нийт 8 ажлаас Баруунбүрэн суманд гүний худаг гаргах ажилд хугацаа хэтрүүлсэн хоног тутмын алданги 0.6 сая төгрөгийг тооцсон бол бусад 6 төсөл, арга хэмжээ 1-4 сараар хугацаа хэтрэлттэй байгаа бөгөөд комисс бүрэн хүлээж аваагүй байгаа тул алданги тооцоогүй байна. Хугацаа хэтрэлттэй ажлуудыг дурдвал:

1. Ерөө сумын 2-р багийн Дарь эх хэсгийн шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамж, дэд станц - 4 сар;
2. Хүдэр сумын Тарвагатай 1-р багт 04 квт-ын шугам татах - 4 сар;
3. Хүдэр сумын гэр хорооллын гудамж талбайн гэрэлтүүлэг - 3 сар;
4. Орхон сумын эмнэлгийн ариун цэврийн байгууламж, морг, гражийн засвар - 4 сар;
5. Орхонтуул сумын эмнэлгийн морг, гражийн засвар -1 сар;
6. Хушаат сумын соёлын төвийн дээвэр засвар - 56 хоног.

3.3.6 Тайлант онд харьцуулалтын аргаар хийгдсэн ажлуудаас тендерт нэг ч санал ирээгүй, үнийн санал ирүүлсэн боловч шаардлага хангаагүй шалтгаанаар дараах ажлуудыг төсөвт өртгөөр нь шууд гэрээ байгуулж, гүйцэтгүүлсэн байна. Үүнд:

1. 80.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сүхбаатар сумын 8-р багийн Буурын голд дулааны шугам шинээр татах ажил” - гүйцэтгэгч “Эцэг эх хүү” ХХК;
2. 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сүхбаатар сумын 3-р багийн Салхитын аманд дулааны шугам шинээр татах ажил” - гүйцэтгэгч “Эцэг эх хүү” ХХК;
3. 70.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Зүүнбүрэн сумын уурын зуухны тогоо солих ажил” - гүйцэтгэгч “Эл си би” ХХК;
4. 15.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд автомашин худалдан авах” - гүйцэтгэгч “Нарт оргил өргөө” ХХК;
5. 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Үндэсний өв соёлыг дэлгэрүүлэх зорилготой сумдад нум сум худалдан авах” - гүйцэтгэгч “Хөвчит хум” ХХК;
6. 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сүхбаатар сум 24-р байрны сантехникийн шугам сүлжээний засварын ажил” - гүйцэтгэгч “Есөн хэлхээ” ХХК;
7. 30.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Аймгийн Музейн барилгын дээврийн их засварын ажил” – гүйцэтгэгч “Тотал импекс” ХХК зэрэг болно.

3.3.7 Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 40.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хүдэр сумын гэр хорооллын гудамж талбайн гэрэлтүүлэг”-ийн ажлыг “Цац эрчис” ХХК-тай 35.4 сая төгрөгөөр гүйцэтгүүлэх гэрээ байгуулсан боловч нэмэлт ажлын гэрээ байгуулан нийт 40.7 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг **0.7** сая төгрөгөөр хэтрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-д “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэж заасныг зөрчиж байна.

3.3.8 Тайлант онд ОНХС болон аймгийн ХО-аар хийж гүйцэтгэсэн дараах төсөл, арга хэмжээнүүдэд нэмэлт ажлын гэрээ байгуулж, гүйцэтгүүлсэн байна.

Нэмэлт гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн төсөл, арга хэмжээ

Хүснэгт №9 /сая төгрөгөөр/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Гүйцэтгэсэн компани	Гэрээний дүн	Нэмэлт гэрээний дүн
Нэг. Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт					
1.1	Алтанбулаг суманд Цэнгэлдэх хүрээлэн барих	80.0	"Сэлэнгэ таван хан"ХХК	70.4	6.2
1.2	Албанбулаг суманд морь барианы талбай барих	20.0	"Сэлэнгэ таван хан"ХХК	17.8	2.2
1.3	Ерөө сумын сургуулийн спорт заалны шалны засвар	31.6	"Амар реконстракшн" ХХК	26.8	4.0
Нийт дүн		131.6		115.0	12.4
Хоёр. Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалт					
2.1	Ерөө сумын 1-р багийн Энхтал хэсгийн шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамж, дэд станц	49.9	"Санивера" ХХК	41.4	6.0
2.2	Ерөө сумын 2-р багийн Дарь эх хэсгийн шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамж, дэд станц	49.4	"Гандирын тал" ХХК	44.7	4.1
2.3	Хүдэр сумын Тарвагатай 1-р багт 04 кв-ын шугам татах	39.5	"Сэнжийн говь" ХХК	38.8	0.7
2.4	Хүдэр сумын гэр хорооллын гудамж талбайн гэрэлтүүлэг	40.0	"Цац эрчис" ХХК	35.4	5.3
2.5	Мандал сумын Хэрх тосгоны сургуулийн цонх шинэчлэн засварлах	49.0	"Амар реконстракшн" ХХК	44.9	4.1
Нийт дүн		227.8		205.2	20.2

3.3.9 ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Ерөө сумын 1-р багийн Энхтал хэсгийн шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамж, дэд станцын ажлын **6.0** сая төгрөгийн, Ерөө сумын 2-р багийн Дарь эх хэсгийн шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамж, дэд станцын ажлын **4.1** сая төгрөгийн тус тус нэмэлт ажлын гэрээ байгуулж, гүйцэтгэсэн гэж байгаа ч нэмэлтээр ажил гүйцэтгэснийг нотлох баримтгүйгээр санхүүжилтийг тооцож олгосон нь Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам"-ын 4 дэх "Төсвийн хөрөнгө оруулалтын төсөлт арга хэмжээг санхүүжүүлэх" хэсгийн 4.3, 4.6, 4.8, 4.9 гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Бүлэг 4

Төсвийн ерөнхийлөн захирагчдын хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүн зорилтот түвшинд нийцсэн үү?

Аймаг, сумдын ИТХ нь төсвийн эрх захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг Төсвийн тухай хуулийн 22.6.5, 22.6.6-д заасны дагуу батлаагүй байна.

4.1 ТЕЗ-ийн хэрэгжүүлж буй хөтөлбөр арга хэмжээний чанарын болон тоон үзүүлэлт зохистой байж чадсан эсэх?

Төсвийн эрх захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг төсвийн зарлагын хөтөлбөрийн ангилал болон тоон үзүүлэлтээр батлаагүй байна.

4.1.1 Төсвийн тухай хуулийн 22.6.5¹, 22.6.6², 32.2.11³ дэх заалт болон Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалын 2-р хавсралтаар баталсан загвар маягтын дагуу аймаг болон сумдын ИТХ-ын тогтоолоор төсвийн эрх захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн чанар болон тоон үзүүлэлт, зарцуулах төсвийг батлах ёстой байдаг.

4.1.2 Аймгийн ИТХ-ын 2018 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 38 дугаар тогтоолоор 14 хөтөлбөр, 52 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тодотгон баталсан боловч төсвийн эрх захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөрийг арга хэмжээгээр нь задлаагүй, хүрэх үр дүнгийн тоон үзүүлэлтийг тусгаж батлаагүй байна. Үүнд:

- *Аймгийн ИТХ-ын үйл ажиллагаа, Засаг даргын ажлын алба, Орон нутгийн өмчийн газар, Санхүүгийн хяналт, аудитын алба гэх мэт тус бүр 1 хөтөлбөрөөр баталж, хэдэн арга хэмжээ хэрэгжүүлэх, ямар тоон үзүүлэлтэд хүрэх нь тодорхой бус.*
- *Тусгай зориулалтын шилжүүлгээр хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ, ерөнхий боловсролын үйлчилгээ гэх мэт тус бүр 1 хөтөлбөрөөр баталж, хэдэн цэцэрлэг, сургууль хамрагдаж, хэдэн арга хэмжээ хэрэгжүүлэх, ямар тоон үзүүлэлтэд хүрэх нь тодорхой бус байна.*

4.1.3 Төсвийн эрх захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн чанар болон тоон үзүүлэлт, зарцуулах төсвийг сумдын ИТХ-ын тогтоолоор хэрхэн баталсныг авч үзвэл:

- *Алтанбулаг, Баянгол, Орхонтуул, Сайхан, Сүхбаатар, Шаамар сумын ИТХ нь төсвийн эрх захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөрийг арга хэмжээгээр нь задлаагүй, сумын ИТХ, Засаг даргын ажлын алба, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ, ерөнхий боловсролын үйлчилгээ гэх мэт тус бүр 1 хөтөлбөрөөр, хэдэн арга хэмжээ хэрэгжүүлэх, ямар тоон үзүүлэлтэд хүрэх нь тодорхой бус баталсан,*
- *Зүүнбүрэн, Ерөө, Мандал, Хүдэр сум төсвийн эрх захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнг чанар болон тоон үзүүлэлтээр батлаагүй,*
- *Баруунбүрэн, Хушаат сум тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг батлаагүй,*
- *Орхон, Сант, Түшиг сум төсвийн эрх захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг огт батлаагүй байна.*

¹ төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төсвийн төвлөрүүлэн захирагч бүрээр, төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагдахгүй төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар, хүрэх үр дүнгийн хамт батлах;

² төсвийн төвлөрүүлэн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар, хүрэх үр дүнгийн хамт батлах;

³ төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, тэдгээртэй холбогдсон тайлбар, танилцуулга;

4.1.4 Харин Жавхлант, Цагааннуур сумд ИТХ, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх хөтөлбөрийг арга хэмжээ бүрээр, чанар болон тоон үзүүлэлттэйгээр баталсан байна.

4.2 ТЕЗ-д 2018 оны батлагдсан хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлж, төсвийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх?

Батлагдсан хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхдээ холбогдох тушаал, зааврыг мөрдөж байгаа боловч төсвийн гүйцэтгэлийг хууль, журмын дагуу тайлагнаагүй байна.

4.2.1 Төсвийн тухай хуулийн 54.5.1⁴, 54.5.4⁵-д заасны дагуу аймаг, сумын төсвийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан нь хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулгын хамт бэлтгэгдэх ёстой.

4.2.2 Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар Төсвийн зарлагын хөтөлбөрийн ангиллыг, хоёрдугаар хавсралтаар Зардлын зориулалт арга хэмжээний ангиллыг баталсан байна.

4.2.3 Аймгийн СТСХ болон сумдын Санхүүгийн алба нь батлагдсан хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхдээ дээрх тушаал, зааврыг мөрдөж байгаа боловч төсвийн гүйцэтгэлийг тайлагнахдаа Төсвийн тухай хуулийн 54.5.1 , 54.5.4 -д заасныг мөрдөж ажиллахгүй байна.

4.2.4 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх талаар хийсэн тулган баталгаажуулалтын дүнг аудитын тайлангийн 3 дугаар бүлэгт тодорхой дурдсан болно.

4.3 Хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтэд тавих дотоод хяналт үр дүнтэй байгаа эсэх?

Хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн дотоод хяналт, шалгалт хангалтгүй байна.

⁴ тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр/;

⁵ хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/;

4.3.1 Төсвийн тухай хуулийн 69.1⁶-д заасны дагуу аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба орон нутгийн төсвийн орлого, зарлагын төлөвлөлт, гүйцэтгэл, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд дотоод хяналтыг хэрэгжүүлэх ёстой.

4.3.2 Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2018 онд Сангийн яамны болон өөрийн төлөвлөгөөгөөр дараах хяналт шалгалтыг хийсэн байна. Үүнд:

- *Сангийн яамны нэгдсэн удирдамжаар аймгийн Татварын хэлтсийн 2016, 2017 оны санхүү, татварын үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалтаар орон нутгийн төсвийн орлого төлөвлөлт, бүрдүүлэлт, хуваарилалт, төсвийн зардлын гүйцэтгэлд аудит хийж дүгнэлт, зөвлөмж өгсөн байна.*
- *Шаамар сумын төрийн сангийн 2016, 2017 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалтаар тус сумын 2016, 2017 оны төсвийн орлого төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалтад аудит хийж дүгнэлт, зөвлөмж өгсөн байна.*

4.3.3 Дээр дурдсанаас бусад тохиолдолд буюу аймгийн төсвийн орлого, зарлагын төлөвлөлт, гүйцэтгэл, орон нутгийн төсөвт томоохон байр суурь эзэлдэг хөрөнгө оруулалт, ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэл, худалдан авах үйл ажиллагааны зохион байгуулалт, тусгай сангуудын үйл ажиллагаа болон эдгээрт холбогдох хууль, эрхийн актуудын хэрэгжилтэд хяналт шалгалт хийгдээгүй байна. Өөрөөр хэлбэл аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас орон нутгийн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилтэд тавих хяналт шалгалт хангалтгүй байна гэж дүгнэж байна.

4.3.4 Аудитад хамрагдсан хугацаанд сумдын Санхүүгийн албаны зүгээс тус тусын сумдын төсвийн орлого бүрдүүлэлт, зарцуулалт, хэрэгжилтэд хяналт, шалгалт огт хийгдээгүй байна.

⁶ Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.

Илэрсэн зөрчил

Хийж гүйцэтгэсэн аудитын дүнгээр нийт **2,113.7 сая төгрөгийн** алдаа, зөрчил илэрснээс **774.1** сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, **1,339.6** сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв. Үүнд:

Албан шаардлага:

- Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалтыг зөрчин зайлшгүй шаардлага үүсээгүй байхад зарлагыг нэмэгдүүлэх зорилгоор төсөвт тодотгол хийсэн нийт **714.0** сая төгрөг;
- Засгийн газраас нөөц сангаас олгосон санхүүжилтийг төсөвт сууж батлагдаагүй арга хэмжээнд зориулалт бусаар зарцуулсан бөгөөд зарцуулсны дараа төсөвт тусгаж баталсан **50.0** сая төгрөг;
- ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 2 төсөл, арга хэмжээнд нэмэлт ажил гүйцэтгэснийг нотлох баримтгүйгээр олгосон 10,1 сая зэрэг нийт **774.1** сая төгрөгийн зөрчилд тус тус зөрчил арилгуулах албан шаардлагыг хүргүүлэв.

Зөвлөмж:

- Төсвийн төлөвлөлттэй холбоотой нийт **1,181.9** сая төгрөгийн;
- Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой нийт **157.7** сая төгрөгийн зэрэг нийт **1,339.6** сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөгдөв. */Дэлгэрэнгүйг Хавсралт №4-т харуулав/*

Аудитын дүгнэлт

Сэлэнгэ аймгийн 2018 оны төсвийн гүйцэтгэлийн явцад хийсэн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- УИХ-аар хянагдаж ирсэн ус ашигласны төлбөрийн орлогыг аймгийн ИТХ-ын тогтоолоор үндэслэлгүйгээр нэмэгдүүлэн баталсан байна.
- Зураг төсөвгүй, техник эдийн засгийн үндэслэл хийгдээгүй төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалт болон ОНХС-ийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.
- УИХ-аар хянагдаж ирсэн аймгийн ИТХ-ын урсгал зардлыг анхны батлагдсан төсвөөр 2.6 дахин нэмэгдүүлсэн бол төсвийн тодотголоор дахин 16.5 хувиар нэмэгдүүлэн баталсан байна.
- Аймаг, сумын төсвөөс улсын төсвийн байгууллагуудын урсгал болон хөрөнгө худалдан авах зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.
- Нэгтгэж, нэг багц болгон төлөвлөж, хэрэгжүүлэх боломжтой хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг салгаж төлөвлөсөн байна.

- Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус тухайн байгууллагын урсгал зардалд тусган, хэрэгжүүлэх боломжтой урсгал зардлыг орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлсэн байна.
- Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан зайлшгүй нөхцөл, шаардлага үүсээгүй байхад аймаг, сумдын төсөвт 1-2 удаа тодотгол хийж, орон нутгийн төсвийн орлого, зарлагыг **714.0** сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.
- Орон нутгийн өмчийг ашиглан халаалтын үйлчилгээ үзүүлж буй хувийн компаниудаас түрээсийн орлого төвлөрүүлэх нөөц боломжийг ашиглаагүй байна.
- Орон нутгийн нийт төсөв ХБГ-ээр хэмнэгдэх төлөвтэй байгаагийн 47.9 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал, 28.2 хувийг хөрөнгийн зардал, 23.9 хувийг бусад зардал эзэлж байна.
- Засгийн газрын нөөц сангаас өвөлжилтийн бэлтгэл ажилд зориулан олгосон санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулсан байна.
- Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 6 төсөл, арга хэмжээнд ажил гүйцэтгэх хугацаа хэтрүүлсний алданги нийт 3.8 сая төгрөгийг тооцоогүй байна.
- ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 2 ажил, арга хэмжээнд нэмэлтээр ажил гүйцэтгэснийг нотлох баримтгүйгээр санхүүжилт олгосон байна.
- Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах зардлыг зарцуулах журмын зарим заалтууд нь холбогдох хууль, журамтай нийцэхгүй байна.
- Төсвийн эрх захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг төсвийн зарлагын хөтөлбөрийн ангилал болон тоон үзүүлэлтээр батлаагүй байна.
- Төсвийн тухай хуулиар батлагдсан хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхдээ холбогдох тушаал, зааврыг мөрдөж байгаа боловч төсвийн гүйцэтгэлийг хууль, журмын дагуу тайлагнаагүй байна.
- Хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтэд дотоод хяналт хийгдээгүй байна.

Аудитын зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Нэг. Аймаг, сумдын ИТХ-н дарга нарт:

- Төсвийн эрх захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг Төсвийн тухай хуулийн 22.6.5, 22.6.6-д заасны дагуу эдийн засгийн ангилал, хөтөлбөр, арга хэмжээгээр хүрэх үр дүнгийн хамт батлах.

**Хоёр. Аймгийн Засаг дарга Ш.Оргил,
ЗДТГ-ын СТСХ-ийн дарга М.Нарантуяа нарт:**

- Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан орон нутгийн төсөвт зайлшгүй тодотгол хийх нөхцөл байдал үүссэнээс бусад тохиолдолд төсөвт тодотгол хийж, хөрөнгө оруулалтын болон урсгал зардлуудыг санхүүжүүлэхгүй байх.
- УИХ-аар хянагдаж ирсэн орон нутгийн төсвийн орлого, зарлагыг, үүний дотор усны орлогыг үндэслэлгүйгээр нэмэгдүүлэн, төлөвлөж буй сүүлийн 3 жил дараалан гарч буй зөрчлийг таслан зогсоох.
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг холбогдох хууль, журамд заасны дагуу төлөвлөж хэрэгжүүлэх, үүний дотор урсгал зардлыг бус, бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжүүлэх.
- Зураг төсөвгүй, техник эдийн засгийн үндэслэл хийгдээгүй төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалт болон ОНХС-гийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлэхгүй байх.
- Татварын авлагыг барагдуулах тал дээр тодорхой арга хэмжээ авч, бүрэн төвлөрүүлэх
- Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулах, нээлттэй тендерээс зайлсхийх зорилгоор хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг шууд худалдан авах болон харьцуулалтын аргын босго үнэд багтаан, салган төлөвлөж, хэрэгжүүлж буй зөрчлийг таслан зогсоох.
- Замын хураамжийн орлогыг Авто замын тухай хуулийн 24.3-д заасны дагуу орон нутгийн чанартай авто замын арчлалт, засварын ажлыг санхүүжүүлэхэд зарцуулах.
- Тусгай зориулалтаар улсын төсвөөс болон Засгийн газрын нөөц сангаас олгосон санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулах.
- Төсвийн тухай хуулийн 54.5.1, 54.5.4-д заасны дагуу аймгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг хөтөлбөрөөр тайлагнаж, хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнг танилцуулгын хамт бэлтгэж байх.
- Батлагдсан төсвийг хэмнэлттэй, үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулж ажиллахыг холбогдох төсвийн захирагч нарт үүрэг болгож, үр нөлөө бүхий дотоод хяналтыг хэрэгжүүлэх.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

Б.БАТМӨНХ

А.ДАШБАТ

Тодотгол хийгдсэн сумдын судалгаа

/Сая төгрөгөөр/

№	Татварын нэр төрөл	Анх батлагдсан дүн	Тодотголын дүн	Нэмэгдсэн дүн
Мандал сум /2 удаа тодотгол хийсэн-2018.09.11 №58/				
1	Хөрөнгийн орлого	72.8	212.3	139.5
2	Улсын тэмдэгтийн хураамжийн төлбөр	40.0	42.8	2.8
3	Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	4.0	7.7	3.7
4	Ойн нөөц ашигласны төлбөр	310.2	510.2	200.0
5	Ус рашаан ашигласны төлбөр	1.5	12.0	10.5
6	Хог хаягдлын хураамжийн төлбөр	50.2	51.4	1.2
7	Хөрөнгө борлуулсны орлого	50.0	84.4	34.4
8	Хүү торгуулийн орлого	146.0	205.0	59.0
9	Нэр зааж ангилагдаагүй бусад орлого	50.0	82.0	32.0
10	ОНТБ-ын өөрийн орлого	23.3	41.1	17.8
Тодотгол хийгдсэн дүн				500.9
Сүхбаатар сум /2удаа тодотгол хийсэн-2018.09.10 №10/				
1	Хөрөнгийн орлого	608.8	641.3	32.5
2	Хүү торгуулийн орлого	50.0	80.0	30.0
3	Нэр зааж ангилагдаагүй бусад орлого	6.0	20.0	14.0
4	ОНТБ-ын өөрийн орлого	0.5	8.0	7.5
Тодотгол хийгдсэн дүн				84.0
Алтанбулаг сум /2018.04.25 №52/				
1	ОНТБ-ын өөрийн орлого	0.5	1.0	0.5
Тодотгол хийгдсэн дүн				0.5
Баянгол сум /2018.05.11 №60/				
1	Хүү торгуулийн орлого	45.0	50.0	5.0
2	ОНТБ-ын өөрийн орлого	15.5	18.5	3.0
Тодотгол хийгдсэн дүн				8.0
Сайхан сум /2018.05.09 №11/				
1	Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	44.6	62.2	17.6
2	Хүү торгуулийн орлого	61.6	64.6	3.0
Тодотгол хийгдсэн дүн				20.6
НИЙТ ТОДОТГОСОН ДҮН				614.0

Орон нутгийн төсвийн байгууллагуудын өөрийн орлогын судалгаа

/Сая төгрөгөөр/

№	Байгууллага	Сум	2018 оны		2018 оны 3-р улирлын		Биелэлт дүн	Биелэлт хувь
			Төл	ХБГ	Төл	Гүйц		
1	ЗДТГ	Алтанбулаг	1.0	1.1	0.9	1.0	0.14	116%
2	Ойн анги	Ерөө	24.3	25.7	16.2	17.6	1.37	108%
3	ЗДТГ	Зүүнбүрэн	9.7	10.3	6.0	6.6	0.58	110%
4	Ойн анги	Мандал	17.6	36.3	13.0	31.7	18.70	244%
5	ЗДТГ	Мандал	1.2	1.2	0.9	0.9	-	100%
6	Захирагчийн алба	Түнхэл	6.5	5.8	4.9	4.1	(0.73)	85%
7	ЗДТГ	Орхон	1.0	1.2	0.7	1.0	0.23	131%
8	Ойн анги	Цагааннуур	15.6	24.1	11.7	20.2	8.45	172%
9	ЗДТГ	Цагааннуур	0.5	3.3	0.4	3.1	2.77	891%
10	ЗДТГ	Баянгол	18.5	15.7	14.3	11.5	(2.77)	81%
11	ЗДТГ	Орхонтуул	0.5	1.9	0.4	1.7	1.37	480%
12	Ойн анги	Баруунбүрэн	15.6	13.6	11.2	9.2	(2.03)	82%
13	ЗДТГ	Баруунбүрэн	17.6	16.3	13.2	11.9	(1.31)	90%
14	ЗДТГ	Шаамар	0.5	1.5	0.4	1.3	0.96	357%
15	Захирагчийн алба	Дулаанхаан	1.1	3.7	1.1	3.7	2.54	327%
16	ЗДТГ	Сүхбаатар	0.5	2.0	0.5	1.9	1.45	423%
17	ЗДТГ	Жавхлант	1.5	1.2	1.1	0.8	(0.35)	69%
18	ЗДТГ	Түшиг	0.5	0.6	0.4	0.5	0.12	133%
19	ЗДТГ	Сэлэнгэ аймаг	45.0	48.8	33.8	37.6	3.84	111%
20	Орон нутгийн өмчийн газар	Сэлэнгэ аймаг	8.0	15.1	8.0	15.1	7.09	189%
21	ЗДТГ	Ерөө	0.5	0.1	0.4	-	(0.36)	0%
22	ЗДТГ	Сант	0.5	0.1	0.4	-	(0.37)	0%
23	ОНХС	Орхонтуул	12.0	12.5	12.5	12.5	-	100%
Нийт дүн			199.9	242.1	152.1	193.8	41.70	127%

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын өөрийн орлогын судалгаа

/Сая төгрөгөөр/

№	Байгууллага	Сум	2018 оны		2018 оны 3-р улирлын		Биелэлт дүн	Биелэлт хувь
			Төл	ХБГ	Төл	Гүйц		
1	Соёлын төв	Алтанбулаг	1.0	0.8	0.7	0.5	(0.18)	74.9%
2	Биеийн тамир спортын хороо	Ерөө	0.8	0.8	0.6	0.6	(0.00)	99.9%
3	Соёлын төв	Ерөө	1.1	1.0	0.7	0.6	(0.12)	82.4%
4	Соёлын төв	Ерөө	1.3	0.3	1.0	0.1	(0.98)	4.9%
5	Соёлын төв	Зүүнбүрэн	1.2	1.3	0.9	1.0	0.15	116.2%
6	Биеийн тамир спорт сургалтын цогцолбор	Мандал	19.8	14.4	16.3	11.0	(5.38)	67.1%
7	Мөнгөн хараа чуулга	Мандал	13.1	11.1	10.5	8.6	(1.94)	81.5%
8	ЕБСургууль	Түнхэл	1.2	1.2	0.8	0.8	-	100.0%
9	Соёлын төв	Түнхэл	1.1	0.7	0.8	0.4	(0.42)	47.5%
10	Соёлын төв	Хэрх	1.0	3.6	0.7	3.3	2.63	486.2%
11	Соёлын төв	Сант	1.2	0.9	1.0	0.7	(0.27)	71.5%
12	Биеийн тамир спорт цогцолбор	Цагааннуур	2.5	4.2	1.7	3.4	1.65	197.3%
13	Соёлын төв	Цагааннуур	1.2	1.2	0.8	0.8	-	100.0%
14	Биеийн тамир спорт цогцолбор	Баянгол	0.8	1.0	0.6	0.8	0.24	139.5%
15	Соёлын төв	Баянгол	1.2	0.9	0.9	0.6	(0.29)	68.0%
16	Биеийн тамир спорт цогцолбор	Сайхан	4.0	3.7	2.8	2.5	(0.35)	87.7%
17	Соёлын төв	Сайхан	12.0	12.7	8.6	9.3	0.74	108.7%
18	Соёлын төв	Номгон	1.0	0.9	0.7	0.6	(0.10)	85.9%
19	Соёлын төв	Орхонтуул	1.3	0.7	0.9	0.4	(0.55)	41.7%
20	Соёлын төв	Баруунбүрэн	1.0	0.8	0.8	0.6	(0.16)	80.1%
21	Биеийн тамир спорт цогцолбор	Баруунбүрэн	1.5	1.6	1.0	1.1	0.08	108.3%
22	Соёлын төв	Шаамар	1.3	1.0	0.9	0.6	(0.24)	71.2%
23	Соёлын төв	Дулаанхаан	7.3	6.4	7.1	6.2	(0.85)	88.0%
24	Соёлын төв	Хүдэр	1.2	1.0	0.9	0.7	(0.18)	80.1%
25	ЕБ-н 3-р сургууль	Сүхбаатар	-	0.4	-	0.4	0.39	
26	Цэцэрлэг	Жавхлант	1.4	1.4	1.4	1.4	-	100.0%
27	Соёлын төв	Жавхлант	1.0	1.0	0.7	0.7	(0.04)	94.0%
28	Соёлын төв	Түшиг	1.0	0.9	0.9	0.8	(0.10)	89.4%
29	ЕБСургууль	Хушаат	2.3	1.2	2.3	1.2	(1.13)	50.5%
30	Соёлын төв	Хушаат	1.1	1.7	0.8	1.4	0.61	181.3%
31	Биеийн тамир спортын газар	Сэлэнгэ аймаг	27.4	28.6	25.2	26.4	1.22	104.8%
32	Аймгийн төв номын сан	Сэлэнгэ аймаг	0.2	0.3	0.1	0.3	0.17	252.0%
33	Сэлэнгийн долгио чуулга	Сэлэнгэ аймаг	23.8	15.2	17.8	9.3	(8.53)	52.2%
34	Спорт сургууль	Сэлэнгэ аймаг	3.6	1.3	3.6	1.3	(2.26)	36.9%
35	Нэгдсэн музей	Сэлэнгэ аймаг	3.2	3.5	2.4	2.7	0.29	112.1%
36	Соёлын төв	Орхон	1.0	0.1	0.9	-	(0.86)	0.0%
37	Сургууль	Түшиг	0.7	0.4	0.4	-	(0.36)	0.0%
Нийт дүн			145.4	128.3	118.0	100.8	(17.12)	85.5%

Аудитаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэгдсэн алдаа зөрчлийн нэгтгэл

№	Илэрсэн зөрчлын утга	Зөрчлийн дүн /сая төгрөгөөр/
Төсвийн төлөвлөлттэй холбоотой алдаа зөрчил		
1	Зураг төсөв хийгдээгүй төсөл, арга хэмжээг орон нутгийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр баталсан.	762.5
2	Аймаг, сумын төсвөөс улсын төсвийн байгууллагуудын урсгал болон хөрөнгө худалдан авах зардалд санхүүжилт олгохоор төлөвлөсөн.	183.1
3	Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлуудаас нэгтгэж, нэг багц болгон төлөвлөж, хэрэгжүүлэх боломжтой 4 төсөл, арга хэмжээг салгаж төлөвлөсөн.	213.0
4	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад хөрөнгө оруулалтын шинж чанартай бус тухайн байгууллагын урсгал зардалд тусган, хэрэгжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлсэн.	23.3
Алдаа зөрчлийн дүн		1,181.9
Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой алдаа зөрчил		
5	Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тушаалыг зөрчин баяр наадмын зардлыг хэтрүүлэн зарцуулсан.	55.7
6	Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 40.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хүдэр сумын гэр хорооллын гудамж талбайн гэрэлтүүлэг”-ийн ажилд нэмэлт гэрээ хийж батлагдсан төсвийг хэтрүүлсэн.	0.7
7	Замын хураамжийн орлогыг аймгийн нэр зааж ангилагдаагүй бусад орлогын дансанд төвлөрүүлдэг болсонтой холбоотойгоор орон нутгийн чанартай авто замын арчлалт, засварын ажлыг санхүүжүүлэхэд бус бусад урсгал зардалд зарцуулсан.	82.8
8	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн зардлаас хөрөнгө оруулалтын шинж чанартай арга хэмжээнд хөрөнгө зарцуулсан.	14.7
9	Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын ажлуудаас гэрээний хугацаа хэтрүүлсэн 6 төсөл, арга хэмжээнд алданги тооцоогүй.	3.8
Алдаа зөрчлийн дүн		157.7
Зөвлөмж өгөгдөх нийт алдаа зөрчлийн дүн		1,339.6

**АЙМГИЙН ЗДТГ-ЫН САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСЭЭС
ИРҮҮЛСЭН САНАЛ, ТАЙЛБАР**



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

213200 Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг
Утас/Факс: 7036-3834

2018.11.01 № 7/158
танай 102/10.10-ны № 152-т

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

“2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц” сэдэвт аудитын тайлангийн төсөлтэй танилцан саналаа хүргүүлж байна.

Хавсралт / хуудас.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА М.НАРАНТУЯА



1. Төсвийн орлогын талаар

Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн 15, 16 дугаар зүйлд Сэлэнгэ аймагт олгогдох санхүүгийн дэмжлэг болон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг баталдаг.

Аудитын тайлангийн төсөлд усны орлогыг 452.4 сая төгрөгөөр УИХ-аар батлагдаж ирсэн ч тус орлогыг нэмэгдүүлсэн байна гэж дүгнэжээ. Энэ нь дээрх хуулийн заалтанд аймгийн төсвийн ямар ч орлого, зарлагын дүнг УИХ баталдаггүй зөвхөн санхүүгийн дэмжлэгийг тооцоолсон тооцооллоор санхүүгийн дэмжлэгийн хэмжээг тодорхойлж тус дүнгээр хуульд оруулдаг болно.

Тайлбар 1-ийг үзнэ үү.

Аймаг өөрийн орлогын нөөц бололцоонд тулгуурлан төсвөө батлах бүрэн боломжтой. Аймагт олгох санхүүгийн дэмжлэг нь тусламжийн орлогод тооцогдон аймгийн төсөвт тусгагддаг. Иймээс УИХ-аас баталсан орлогыг үндэслэлгүй нэмэгдүүлсэн гэдэг дүгнэлтийг өгөх нь хуулийн ямар ч заалтанд байхгүй тул энэхүү дүгнэлтийн саналыг хүлээн авах боломжгүй.

Орон нутагт ОНХСангаас өөр тусгай сан байх ёсгүй гэсний дагуу замын санг татан буулгаж замын хураамжийн орлогыг нэр зааж ангилагдаагүй бусад орлогод төвлөрүүлдэг. Замын хураамжийн орлого нь татварын бус орлого юм.

2. Төсвийн тодотгол хийсэн гэсэн дүгнэлтийн талаар

Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн дагуу улсын төсөв болон орон нутгийн төсөв тодотгол хийдэг. 2018 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн "Сэлэнгэ аймгийн 2018 оны төсөвт урьд оны үлдэгдэл нэмж батлах тухай" 38 дугаар тогтоолоор аймгийн төсөвт өөрчлөлт орсон. Тус тогтоолын үндэслэл нь Төсвийн тухай хуулийн 57.3 "Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна." заалтын дагуу 2017 оны орон нутгийн төсвийн үлдэгдлийг нэмж баталсан. Энэ нь тодотгол биш тул аудитын саналд төсвийн тодотгол гэсэн дүгнэлтийг хүлээн авах боломжгүй.

Тайлбар 2-ыг үзнэ үү.

3. Улсын төсвийн байгууллагад хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудын талаар

Монгол Улсын Хилийн тухай хуулийн 50.1.1 "5өөрийн нутаг дэвсгэрт байгаа Улсын хил хамгаалах байгууллагын хангалт үйлчилгээнд тусалцаа үзүүлж, Монгол Улсын хилийн тухай хууль тогтоомжийг иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага сахин биелүүлж байгаад хяналт тавих" заалт болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19.1 "Тухайн жилд шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах чиглэлээр улсын орлого болгосон, торгох ял ногдуулж төсөвт тушаасан мөнгөний 40 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан дараагийн жилийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ" заалтын дагуу Хилийн цэргийн ангиуд болон Цагдаагийн газарт тулгамдсан асуудлыг шийдвэрлэж өгсөн болно.

Тайлбар 3-ыг үзнэ үү.

Санхүү, төрийн сангийн хэлтэс

АЙМГИЙН ЗДТГ-ЫН САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ИРҮҮЛСЭН САНАЛ, ТҮҮНД ӨГСӨН ТАЙЛБАР

Тайлбар 1:

1.1 УИХ-аас аймгуудын санхүүгийн дэмжлэгийн дүнг тухайн аймгийн суурь орлого, зарлагын тооцоолол дээр үндэслэн баталдаг. УИХ-аас Сэлэнгэ аймгийн санхүүгийн дэмжлэгийг батлахдаа суурь орлогын усны төлбөрийн орлогыг 452.4 сая төгрөг байхаар тооцоолсон байна. Харин аймаг тус орлогыг үндэслэлгүйгээр 197.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, **650.0 сая** төгрөгөөр баталснаас тайлант оны 3-р улирлын байдлаар **162.6** сая төгрөгөөр тасарч байгаа бөгөөд 2018 оны ХБГ-ээр ч төлөвлөгөө тасрах төлөвтэй байна. Иймд тус тайлбарыг хүлээн авах боломжгүй бөгөөд УИХ-аас батлагдсан гэдгийг УИХ-аас хянагдаж ирсэн гэж өөрчлөв.

1.2 Замын хураамжийн орлогын хувьд замын санг хааж, замын хураамжийн орлогыг нэр зааж ангилагдаагүй орлогод төвлөрч байгааг зөрчилд тооцоогүй бөгөөд тус орлогыг Авто замын тухай хуулийн 24.3-д заасны дагуу орон нутгийн чанартай авто замын арчлалт, засварын ажлыг санхүүжүүлэхэд зарцуулагдахгүй байгаа талаар тайланд тусгаж бичсэн болно. Иймд тус саналыг хүлээн авах боломжгүй.

Тайлбар 2:

Аудитын тайланд урьд оны мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг тооцолгүйгээр, төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлттэй уялдуулан аймаг, сумдын төсвийн орлого, зарлагыг нийт **714.0** сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосон зөрчлийг тусгасан тул дээрх саналыг хүлээн авах боломжгүй.

Тайлбар 3:

Төсвийн тухай хуулийн 6.6.6-д “*Тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх*” гэж заасан тул улсын төсвөөс санхүүждэг байгууллагуудад орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилтийг зөрчлөөр тооцсон болно. Мөн аймгийн ГХУСАХ-ний санхүүжилтийг тусад нь баталдаг учир тус саналыг хүлээн авах боломжгүй.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2018 оны 11 сарын 05 өдөр

Дугаар 8/15

Сүхбаатар

АУДИТЫН ТАЙЛАН, ДҮНГ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/188 дугаар тушаалын 5-р хавсралт, 2016 оны А/92 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын журам”-ын 12.40, 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Монгол Улсын Ерөнхий аудиторт Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “2018 оны Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц”-д хийсэн аудитын тайланг баталсугай.

2. Аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулах албан шаардлага, зөвлөмжийн жагсаалтыг Хавсралтаар баталсугай.

3. Аудитын тайланг аймгийн ИТХ-ын дарга Г.Бямбаа, Засаг дарга Ш.Оргил, аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга М.Нарантуяа нарт хүргүүлж, www.audit.mn цахим хуудсаар нийтэд мэдээлсүгэй.

4. Аудитын тайланд тусгагдсан албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Б.Батмөнх/-д даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

Дарга, тэргүүлэх аудиторын
 2018 оны 11 сарын 05 өдрийн
 115 дугаар тушаалын Хавсралт



№	Зөрчлийн утга	Албан шаардлага	Зөвлөмж	Нийт зөрчил
1	Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалтыг зөрчин зайлшгүй шаардлага үүсээгүй байхад зарлагыг нэмэгдүүлэх зорилгоор аймаг болон 5 сумын төсөвт нийт 714.0 сая төгрөгийн тодотгол хийсэн.	714.0		714.0
2	Засгийн газрын 2018 оны 35 дугаар тогтоолоор өвөлжилтийн байдал хүндэрч буйтай холбоотой урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан Засгийн газрын нөөц сангаас олгосон санхүүжилтээс БНХАУ-ын Гуанжоу хотноо зохион байгуулагдах хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн үзэсгэлэн худалдааны арга хэмжээнд оролцох аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, сумдын Засаг дарга нар 41 хүний зардалд буюу төсөвт тусгагдаж, батлагдаагүй зардалд 50.0 сая төгрөгийг зарцуулсан.	50.0		50.0
3	ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Ерөө сумын 1-р багийн Энхтал хэсгийн шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамж, дэд станцын ажлын 6.0 сая төгрөгийн, Ерөө сумын 2-р багийн Дарь ах хэсгийн шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамж, дэд станцын ажлын 4.1 сая төгрөгийн тус тус нэмэлт ажлын гэрээ байгуулж, гүйцэтгэсэн гэж байгаа ч нэмэлтээр ажил гүйцэтгэснийг нотлох баримтгүйгээр санхүүжилтийг тооцож олгосон	10.1		10.1
4	Зураг төсөв хийгдээгүй төсөл, арга хэмжээг орон нутгийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр баталсан.		762.5	762.5
5	Аймаг, сумын төсвөөс улсын төсвийн байгууллагуудын урсгал болон хөрөнгө худалдан авах зардалд санхүүжилт олгохоор төлөвлөсөн.		183.1	183.1

6	Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлуудаас нэгтгэж, нэг багц болгон төлөвлөж, хэрэгжүүлэх боломжтой 4 төсөл, арга хэмжээг салгаж төлөвлөсөн.		213.0	213.0
7	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад хөрөнгө оруулалтын шинж чанартай бус тухайн байгууллагын урсгал зардалд тусган, хэрэгжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлсэн.		23.3	23.3
8	Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тушаалыг зөрчин баяр наадмын зардлыг хэтрүүлэн зарцуулсан.		55.7	55.7
9	Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 40.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Хүдэр сумын гэр хорооллын гудамж талбайн гэрэлтүүлэг"-ийн ажилд нэмэлт гэрээ хийж батлагдсан төсвийг хэтрүүлсэн.		0.7	0.7
10	Замын хураамжийн орлогыг аймгийн нэр зааж ангилагдаагүй бусад орлогын дансанд төвлөрүүлдэг болсонтой холбоотойгоор орон нутгийн чанартай авто замын арчлалт, засварын ажлыг санхүүжүүлэхэд бус бусад урсгал зардалд зарцуулсан.		82.8	82.8
11	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн зардлаас хөрөнгө оруулалтын шинж чанартай арга хэмжээнд хөрөнгө зарцуулсан.		14.7	14.7
12	Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын ажлуудаас гэрээний хугацаа хэтрүүлсэн 6 төсөл, арга хэмжээнд алданги тооцоогүй.		3.8	3.8
Нийт дүн			774.1	1,339.6
			1,339.6	2,113.7